

Улсын дээд шүүхэд

2024.07.23

Улаанбаатар хот

Хяналтын журмаар гомдол гаргах тухай

Нийслэлийн захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн 221/МА2024/0453 дугаартай магадлалыг бүхэлд нь эс зөвшөөрч хяналтын журмаар дараах гомдолыг гаргаж байна.

Захиргааны хэргийн анхан шатны шүүх болон давж заалдах шатны шүүх маргааны зүйлийг буруу тодорхойлж хуулийг зөрүүтэй тайлбарлаж хэрэглэсэн нь хуулийн шаардлагыг хангаагүй гэж үзэж байна.

Хадгаламжийн даатгалын корпораци нь Монгол улсын санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, банкны салбарын хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах тусгайлсан чиг үүргийг хуулийн хүрээнд хэрэгжүүлдэг санхүүгийн зохицуулагч төрийн байгууллага билээ.

Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай /БДМХДТ/ хуульд Хадгаламжийн даатгалын корпораци нь өөрийн чиг үүргийн хүрээнд банкнаас хадгаламж эзэмшигчийн холбогдох мэдээллийг гаргуулах авах эрхтэй байхаар, банк түүний хүрээнд холбогдох мэдээллийг өгөх үүрэгтэй байхаар зохицуулсан.

Тодруулбал, БДМХДТХуулийн 29 дүгээр зүйлд корпорацийг тайлан мэдээ мэдээллээр хангах талаарх банкны үүргийг заасан ба хуулийн 29.1-т “Корпорацийг энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээллийг банк тогтоосон хэлбэрээр, хугацаанд нь Корпорацид хүргүүлнэ гэж, мөн **29.2-т “Корпорацийн хүсэлтээр банк Корпорацийг хуулийн дагуу үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай нэмэлт мэдээллийг тухай бүр гаргаж өгнө”, 29.3-т “Банкны тайлан мэдээ, мэдээлэл ирүүлэх журмыг Үндэсний хороо батална” гэж заасан байдаг.**

Хадгаламжийн даатгалын үндэсний хорооны баталсан Банкны тайлан мэдээ болон мэдээлэл ирүүлэх журмын 2 дугаар зүйлийн 2.2-т “**Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасны дагуу банк нь нэмэлт мэдээллийг ХДК-ийн хүсэлтээр тогтоосон хугацаа, загварын дагуу бэлтгэн хүргүүлнэ**” гэж, мөн журмын 3.5-т “**нэмэлт тайлан болон мэдээ, мэдээлэл нь түүнийг боловсруулах аргачлалтай байж болох ба нэг удаагийн эсвэл тогтмол хугацаагаар байж болно**” гэж заасан.

Дээрх журмын заалтын 2.2-т заасан нөхцөлийг задалж үзвэл Хадгаламжийн даатгалын корпорацийн тодорхой нэмэлт мэдээлэл авахаар банканд хандах, ийнхүү хандахдаа тухайн авах мэдээллийг ямар загвараар авах хэдий хугацаанд банк бэлтгэн ирүүлэх талаар заах ёстой байгаа.

196  
199

Хадгаламжийн даатгалын корпораци нь уг нөхцөлийг хангаж тодорхой авах мэдээллийн загвар болох Нэг харилцагчийн зарчим буюу SCV загвараар мэдээллээ бэлтгэн тодорхой хугацаанд ирүүлэх талаар удаа дараа Худалдаа хөгжлийн банканд хандсан.

Худалдаа хөгжлийн банк нь тухайн загварын дагуу заасан хугацаанд бэлтгэн ирүүлэхгүй байсан тул ийнхүү зөрчлийн хэрэг нээж шийтгэл ногдуулсан байдаг.

Ийнхүү шийтгэл ногдуулахдаа Зөрчлийн тухай хуулийн 11.12 дугаар зүйлийн 8-т /Банк нь Үндэсний хорооноос баталсан банкны тайлан, мэдээ, мэдээлэл ирүүлэх журам зөрчсөн бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно./ үндэсдлэн торгох шийтгэл ногдуулсан.

Гэтэл анхан шатны шүүх ...банкнаас шаардаж буй “нэг харилцагчийн зарчим буюу SCV загвар”-аар авч байгаа мэдээлэл нь Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т заасан Корпораци хуулийн дагуу чиг үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай нэмэлт мэдээлэлд хамаарахгүй байна гэж,

...Корпорациас шаардаж буй нэг харилцагчийн зарчим буюу SCV загвар-т тусгасан нэмэлт мэдээлэл нь хуульд заасан нэмэлт мэдээлэлд хамаарахгүй бөгөөд уг загвараар банкнаас мэдээлэл шаардсан, ирүүлээгүй тохиолдолд шийтгэл ногдуулах үр дагавар үүсгэсэн шинжээрээ захиргааны хэм хэмжээний акт байна гэж дүгнэж, Улмаар захиргааны ерөнхий хуулийн холбогдох заалтыг дурдаж ...нэг харилцагчийн зарчим буюу SCV загвар-аар банкнаас мэдээлэл шаардаж, уг загварын дагуу мэдээлэл ирүүлээгүй үндэслэлээр Худалдаа хөгжлийн банканд шийтгэл ногдуулсан нь үндэслэлгүй байна гэж дүгнэсэн байгааг хүлээн зөвшөөрөх боломжгүй байгаа.

Учир нь БДМХДТХуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх зохицуулалт нь банк тогтоосон хэлбэр хугацанаад тогтмол тайлан мэдээгээ Корпорациас шалтгаалахгүй өөрөө хүргүүлэхээр, харин хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дах заалт нь Корпорациас хүсэлт гаргаж тэрхүү хүсэлтийн дагуу холбогдох мэдээллийг банк тухай бүр ирүүлэхээр байгаа буюу Корпорациас шалтгаалан өгөх мэдээлэл гэж ойлгох ёстой.

Нэг харилцагчийн зарчим буюу SCV загвар нь Банкны тайлан мэдээ болон мэдээлэл ирүүлэх журмын 2 дугаар зүйлийн 2.2 /Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т дахь хэсэгт заасны дагуу банк нь нэмэлт мэдээллийг ХДК-ийн хүсэлтээр тогтоосон хугацаа, загварын дагуу бэлтгэн хүргүүлнэ/ дахь заалттын хүрээнд түүнд уялдуулан гаргасан хүснэгтэн загвар бүхий нэмэлт мэдээлэл болохоос биш тусдаа бие даасан захиргааны хэм хэмжээний акт биш бөгөөд Банкны тайлан мэдээ, мэдээлэл ирүүлэх журмын хавсралт 1,2-аар гарган ирүүлдэг тайлангаас тусдаа нэмэлт мэдээлэл болно.

Гэтэл нэмэлт мэдээлэл гэдгийг зөвхөн даатгалын хураамж тооцох тайлан болон харилцах хадгаламж эзэмшигчийн тайлантай холбоотой мэдээлэл байх ёстой юмшиг хэт явцуу, Хадгаламжийн даатгалын корпорацийн үйл ажиллагааг хязгаарласан байдлаар дүгнэлт хийсэн хуульд нийцээгүй.

100  
178

Мөн журмын 2 дугаар зүйлийн 2.2-т Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т дахь хэсэгт заасны дагуу банк нь нэмэлт мэдээллийг ХДК-ийн хүсэлтээр тогтоосон хугацаа, загварын дагуу бэлтгэн хүргүүлнэ гэж заасан.

Өөрөөр хэлбэл, Захиргааны хэм хэмжээний акт мөн биш гэхээсээ илүү Корпорацийн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл мөн үү биш үү, Корпорацийн хэрэгжүүлдэг үйл ажиллагаатай холбоотой, хамааралтай мэдээлэл шаардсан байна уу үгүй юу гэдэг нь Маргааны зүйл нь байгаа.

Гэтэл анхан болон давж заалдах шатны шүүх маргааны зүйлээ буруу тодорхойлж дүгнэлт хийж тухайн маргааныг хуульд нийцээгүй байдлаар шийдсэн.

Түүнчлэн БДМХДТ хуулийн 21.1.2.-т “банкны санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлт, **санхүүгийн үзүүлэлт, бусад мэдээллийг банкнаас авах;**” гэж заасан. Энэхүү нэг харилцагчийн зарчим буюу SCV загварт заасан мэдээлэл нь **Корпорацийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээллийг агуулдаг бөгөөд Корпорацийг хуулийн дагуу үүргээ гүйцэтгэхэд чухал ач холбогдол бүхий мэдээлэл байдаг.**

Иймд дээрх үндэслэлээр Нийслэлийн захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн 221/МА2024/0453 дугаартай магадлалыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж өгнө үү.

ГОМДОЛ ГАРГАСАН:

ХАРИУЦАГЧ



Б.ЭНХМАА /ХЯНАН ШАЛГАГЧ, УЛСЫН БАЙЦААГЧ/